**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/185 Арвайхээр

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.6, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай" А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус, Сант, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт, Хархорин сумдын 44.0 мянган га бэлчээрт микробиологийн аргаар мэрэгч амьтантай тэмцэх ажлыг эхлүүлж, сумдтай гэрээ байгуулах, хяналтын цэг авах, уг ажлыг хүлээж авах хуваарь болон томилолтын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардал болох 3,869,980 (гурван сая найман зуун жаран есөн мянга есөн зуун ная) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

6223 11 0340

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны ...04 дугаар
сарын ...03...-ны өдрийн ...А/185... дугаар
захирамжийн хавсралт

# МЭРЭГЧ УСТГАЛЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЖ, СУМДТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛЖ, ХЯНАЛТЫН ЦЭГ АВАХ, УГ АЖЛЫГ ХҮЛЭЭЖ АВАХ ХУВААРЬ

| д/д | Явах маршрут | Сум хооронд явах км | Хяналтын цэг авах км | Нийт явах км | Шатахуун литр | Мөнгөн дүн (мянган төгрөг) | Томилолт (мянган төгрөг) | Тайлбар (мянган төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Арвайхээр-Зүүнбаян-Улаа | 45 | 90 | 135 | 27 | 66,69 | 3хүн*64000=192000 192000*6хоног =1152000 | 11 сумаар 2 удаа явна |
| 2 | Хужирт | 50 | 80 | 130 | 26 | 64,22 | | |
| 3 | Хархорин | 55 | 145 | 200 | 40 | 98,8 | | |
| 4 | Есөнзүйл | 70 | 70 | 140 | 28 | 69,16 | | |
| 5 | Өлзийт | 50 | 90 | 140 | 28 | 69,16 | | |
| 6 | Сант | 80 | 45 | 125 | 25 | 61,75 | | |
| 7 | Төгрөг | 100 | 85 | 185 | 37 | 91,39 | | |
| 8 | Гучин-Ус | 50 | 70 | 120 | 24 | 59,28 | | |
| 9 | Хайрхандулаан | 50 | 110 | 160 | 32 | 79,04 | | |
| 10 | Уянга | 50 | 55 | 105 | 21 | 51,87 | | |
| 11 | Тарагт | 30 | 80 | 110 | 22 | 54,34 | | |
| 12 | Тарагт-Арвайхээр | 35 | | 35 | 7 | 17,29 | | |
| | Нийт | 665 | 920 | 1585 | 317 | 782,99 | 1152,0 | 3869,98 |

-оОо-